


Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2024 оны 07 дүгээр сарын 31-ны өдрийн  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



№ 2024-001-02

СЕНДВИЧ ХАВТАН, ТАВИЛГА, ВАКУМ ЦОНХ, БЕТОН  
ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТӨЛӨВЛӨГӨӨТ  
БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл

1.1. Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж гал түймрийн эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх журам, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сендвич хавтан, тавилга, вакум цонх, бетон зуурмагийн үйлдвэрийн барилга, байгууламжийг хамруулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

2.3. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт гэсэн 2 төрлийн хүрээнд зохион байгуулна.

2.4. Гал түймрийн улсын хяналтын байцаагч нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулалгүйгээр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох арга хэмжээ авна.

2.6. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.7. Шалгалтад хамрагдах объектын судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан удирдамжид заагдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.

2.8. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга хариуцна.

Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд,  
барилга байгууламж

- 3.1. Сендвич хавтангийн үйлдвэр;
- 3.2. Төрөл бүрийн тавилгын үйлдвэр;
- 3.3. Вакум болон модон цонхны үйлдвэр;
- 3.4. Бетон зуурмагийн үйлдвэр.

Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

4.1. Нийслэлийн хяналт шалгалтын  
ажлын хэсгийн ахлагч

Нийслэлийн Онцгой байдлын газрын  
Гал түймрийн улсын хяналтын  
ахлах байцаагч;

Гишүүд

Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн  
Гал түймрийн улсын хяналтын  
ахлах байцаагч, байцаагч нар;

4.2. Орон нутгийн хяналт шалгалтын  
ажлын хэсгийн ахлагч

Төв орон нутгийн Онцгой байдлын  
газрын орлогч, урьдчилан сэргийлэх  
тасгийн дарга;

Гишүүд

Төв орон нутгийн Онцгой байдлын  
газрын Гал түймрийн улсын хяналтын  
ахлах байцаагч, байцаагч нар.

4.3. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 02 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд тус тус зохион байгуулна.

4.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн мэдээг 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2024 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн дотор хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу боловсруулж, зөрчлийг гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудасны хамт Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн [inspector.obeg@gmail.com](mailto:inspector.obeg@gmail.com) цахим хаягаар тус тус ирүүлнэ.

4.5. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар, Ажиллагааны удирдлагын газар тус тус нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.

Тав. Хариуцлага

Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг удирдамжид заагдсан хугацаанд үр дүнгүй зохион байгуулсан гал түймрийн улсын хяналтын байцаагч, тухайн газар хэлтсийн даргад хариуцлага тооцно.

---oOo---